

*Эрдэм шинжилгээний өгүүлэл*  
УДК 821.512.36.0  
DOI 10.18101/3033-1310-2025-4-34-43

### Баатарлагий тууль дахь нумны дүрслэл

© Мягмарсүрэнгийн Одмандах

сэтгүүл зүйн багш,

Ph.D, дэд профессор,

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Монгол Улс, 14191, Улаанбаатар хото, Сүхэ-Батор дүүрэг

odmandakh@msue.edu.mn

**Хураангуй.** Монголчуудын хүн төрөлхтний түүхэнд «монгол нум» гэж нэршүүлэн мөнхөлсөн нумны талаар манай судлаачид археологийн олдвор, хадны зураг, эртний ул мөрийг шинжин судлаж, тодорхой дүгнэлт хийсэн байдаг. Мөн «монгол нум»-ыг судлахад ардын аман зохиолын төрлүүд дотроос баатарлагийн тууль онцгой ач холбогдолтой юм. Баатарлагийн туульд дүрслэгдэж буй нумыг өнөөгийн нум урлаачдын хийж буй нумтай харьцуулахад зарчмын зөрүүгүй байдаг бөгөөд энэ нь археологийн олдвороос гарсан нумтай ч адилхан байгаа нь олон зууны турш нум хийх арга ажиллагаа нь төгс болж, өнөөг хүртэл түүнийг дууриасаар байгааг илтгэж байна. Энэ өгүүлэлээр бид судлаачдын эртний олдвороос гарсан нумыг судалсан судалгааны дүн мэдээг баатарлагийн тууль дахь нумны дүрслэлтэй харьцуулан жиших замаар ижил байгаа эсэхийг судлах оролдлого хийв.

**Түлхүүр үг:** баатарлагийн тууль, нум, аман билэг, тууль.

#### Для цитирования

Мягмарсүрэнгийн Одмандах. Баатарлагий тууль дахь нумны дүрслэл // Бурятский язык и литература в школе. 2025. № 4. С. 34–43.

#### Оршил

Монголчуудын эртний аман зохиол, бичиг соёлын дурсгалд нумны талаар дүрсэлсэн дүр дүрслэл багагүй бий. Энэ нь тэдний амьдралын хэв маяг, нумыг дээдлэх үзэлтэй нь ч салшгүй холбоотой юм. Эртнээс нааш амьдрал ахуй, цэрэг дайны зорилгоор нумыг хэрэглэж, өөрсдийн гэсэн өвөрмөц нумны соёлыг бий болгосон монголчуудын хувьд аман билэг, бичгийн зохиол туурвилдаа тэрхүү нумаа дээдлэх, магтан алдаршуулах хандлага давамгайлж ирсэн бөгөөд хожмын үед ч орчин үеийн ерөөл, магтаал зохион хэлэлцэж ирсэн түүхтэй.

Монголчуудын уран сэтгэмж, ертөнцийг үзэх үзэл нэвт шингэсэн ардын аман зохиолын тууль, үлгэр, зүйр цэцэн үг, мэргэн үг, ерөөл, магтаал зэрэгт нум сумыг магтан дуулсан, харвах арга маяг, уралдаан тэмцээний талаар уран сайхнаар өгүүлсэн нь олонтоо байна.

Бидний олж үзсэнээр монгол угсаатны аман зохиолын аль ч төрлөөс нум сумны талаарх дүр дүрслэлийг олж үзэж болно. Тус дүрслэл нь уран зохиолын уран сайхны шинжийг бүрэн агуулсан байх бөгөөд хэтрүүлэл, амьшуулал, юмшуулал зэрэг уран сайхны аргыг чадмаг ашиглаж, монголчуудын ертөнцийг үзэх үзлийг тод томруун тусган харуулсан байна.

Энэ удаад ардын аман зохиолын хамгийн түгээмэл төрлийн нэг баатарлагийн туульд нумны талаар хэрхэн дүрсэлснийг жишээ баримтаар тодруулан авч үзэв.

Цаашид бусад төрлүүдэд хэрхэн туссан талаар тусгайлан анхааран судлах шаардлагатай юм.

#### **Судалгааны товч тойм**

Монгол ардын баатарлагийн туулийг доктор У. Загдсүрэн (1986), доктор, профессор, академич Х. Сампилдэндэв (1979), доктор Р. Нарантуяа (1991), доктор, профессор Б. Катуу (2013) доктор Т. Баясгалан (2012), доктор, профессор Г. Нандинбилэг (2004), доктор Б. Нанжид (2022), доктор О. Отгонбаатар (2023) нарын зэрэг олон судлаач тал бүрээс судлан шинжилжээ. Ингэхдээ ардын аман зохиолын төрөл, уран сайхны сэтгэлгээний талаас нь анхааран судласан байдаг.

Угсаатны зүйч Х. Нямбуу "... "Жангар", "Бум Эрдэнэ", "Гэсэр" зэрэг туульд нийгмийн байдлыг тод томруун тусгасан учир монголын эртний байдал ялангуяа дундад зууны үеийн монголын цэрэг баатрын гэр орон, хувцас эдлэл хэрэглэл, зэр зэвсэг тэргүүтнийг танин мэдэхэд ач холбогдолтой юм. Эдгээр туульс чухам хэзээ зохиогдсон нь төдийлөн үл мэдэгдэхийн дээр ерөөс эртний нийгмийн байгууллын олон үеийг тусгасан байдаг боловч зонхилон өгүүлсэн зүйлсээр нь холбогдох түүхэн үеийг баримжаалж болно..." [4] гэж тэмдэглэсэн нь туулийг нийгмийн байгууллын тусгал талаас нь эд өлгийн зүйлийн дүрслэлээр дамжуулан тодорхойлж болох юм гэсэн санааг гаргаж, туульсийн баатруудын хувцас эд өлгийн зүйлээр жишээлэн тайлбарлажээ.

Тэгвэл Х. Нямбуу судлаачийн дээрх санааг гүнзгийрүүлж, тууль дахь зэр зэвсгийн зүйлсээр он цаг, газар орныг нь тодорхойлох судалгааг сүүлийн жилүүдэд хийж эхлээд байна. Тууль судлаач, доктор, профессор Б. Катуу (1999, 2004) бүтээлдээ баатрын зэр зэвсгийг хүний нийгмийн байгууллын онцлог, үетэй холбогдуулан судалж, тодорхой дүгнэжээ. Профессор А. Очир, Б. Нанжид (2022) нарын судалгаанд археологийн олдвор, хадны зураг зэрэгтэй харьцуулан туульд гарч буй нум сумны дүрслэлийг тодруулж, аль үед хамаарах тууль болохыг тодорхойлохыг оролдсон нь энэ талаар хийсэн шинэлэг судалгаа болжээ. Археологич, доктор Н. Эрдэнэ-Очир (2014), доктор Д. Одсүрэн (2024) эртний монгол аймгуудын зэр зэвсгийн судалгааг хийж, түүнийг бусад олон аман болон бичгийн эх сурвалжаар тодруулж, нум сумыг ангилан авч үзсэн нь бидний судалгаанд ч шууд хамаатай зүйл юм.

Доктор Х. Мөнхбаяр (2024) эрийн гурван наадмын талаар хийсэн судалгаандаа археологийн эд өлөг, хадны зураг, ардын аман зохиолын жишээ баримтаас мөшгин хөөж, эртний сурвалж бичигт дурдагдсан зүйлтэй харьцуулан судласан байдаг.

Бид энэ судалгаанаас санаа авч баатарлагийн тууль дахь нумны талаарх дүрслэлийг шүүрдэн үзэж, арга технологийн тухай ажиглалт хийв. Ингэснээр цаашид баатарлагийн туулийн дээрх дүрслэлийг өнөөгийн нум хийх технологи-той харьцуулан дүгнэлт хийх боломжтой болох юм.

#### **Нумны үүслийн талаар эрдэмтдийн үзэл баримтлал**

Монгол туулийн дүрслэлээс үзэхэл баатарлаг дайчин эр нум, сум, илд, жад, шор, арам, балт, сэлэм, хутга, элдэн /ташуур/ зэрэг зэвсгүүд голдуу хэрэглэдэг байжээ. Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэдэг нь нум сум юм [2] гэж доктор, профессор Б. Катуу тэмдэглэжээ.

Эртний зэр зэвсэг судлаач А. Дамдинсүрэн "...Хуучин зэвсгийн шувтарга, шинэ чулуун зэвсгийн эхэн үед төв Азид амьдарч байсан хүмүүс өдөр тутмын амьдралынхаа шаардлагаар янз бүрийн зэрлэг амьтдыг агнахын тулд тэдэнтэй биеэр

тулж авлах осолтой хэцүү хөдөлмөрийг хөнгөвчилсөн шинэ зэвсэг болох нум сум зохион бүтээжээ. Энэ нь ач холбогдлоороо гал гаргаж ашигласан, малыг гэрийн болгож гаршуулсан, эргэлдэх дугуйтай модон тэрэг зохион бүтээсэнтэй тэнцэх хүн төрөлхтний оюун ухааны том нээлт юм...” [1] гэсэн байна.

Археологич, доктор Н. Эрдэнэ-Очир “... 12.000-8.000 жилийн тэртээд хүн төрөлхтөнд ч мөн адил хуучин чулуун зэвсгээс шинэ чулуун зэвсэгт аажмаар шилжих, багаж зэвсэг амьдралын хэвшилээ өөрчлөх шилжилтийн үе тохиосон байна. ... Хүн төрөлхтөн хоол хүнсний шинэ эх сурвалжийг хайж эхэлсэн тэр үеэс модны уян хатан, харимхай шинж чанарыг ашиглан холын тусгалтай зэвсэг болох нум сумыг анх зохион бүтээсэн байна. ... Энэ үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдсан бөгөөд зэвсгийн үйлдвэрлэлд гарсан дэвшилт нь нум сумыг бүтээсэн явдал хэмээн судлаачид үздэг байна. Чулуун зэвсгийн үед анхид нум сум хэрэглэж байсны баримт болох хадны зураг Увс аймгийн Сагил сумын нутаг Цагаан голын хөндийд орших Можоогийн хадны зурагт дүрслэгдэн үлдсэн бөгөөд судлаачид 12.000-7.000 жилийн тэртээд холбогдуулан үздэг...” [8] гэж анхлан нум үүссэн он цагийг тодорхойлжээ.

Доктор Д. Одсүрэн “... анхны нумын хэлбэр, бүтцийн тухай баримт бидний үед хадгалагдан үлдсэнгүй. Нумын бүтцийн ихэнхийг мод бүрдүүлэх бөгөөд яс, эвэр, сур, шир, шөрмөс зэрэг органик материал олон мянган жилийн хугацаанд хадгалагдан үлдэх магадлал тун бага юм. Тийм ч учраас чулуун зэвсгийн үеийн нум ямар байсныг сэргээн тодруулах баттай баримт бидэнд алга. Харин нүүдэлчдийн нумын эртний баримтыг хүрлийн үеийн булш оршуулгын биет олдвор, хадны зургийн дүр дүрслэлээс харж болох юм. Тэгэхээр анхны нум сумын бодит баримт бол харвуулын сумны чулуун зэв юм...” [5] гэсэн байна. Хэдийгээр биет олдвор бидэнд олдох нь хомс боловч аман билгээр буюу ардын аман зохиолд тухайн үед ямар эд материалаар нум хийж байсныг дүрслэн үлдээсэн байна гэж үзэж болох юм.

Нум сум хэмээх холын тусгалт зэвсэг анх чулуун зэвсгийн үед бүтээгдэж түүхийн урт хугацааны туршид улам бүр төгөлдөржин хөгжсөн бөгөөд хүн төрөлхтний зэр зэвсгийн түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Төв Азийн нүүдэлчдийн хувьд нум сум ан гөрөө, дайн тулааны гол зэвсэг болсон бөгөөд хожим олныг хамарсан наадам цэнгэлийн нэг төрөл болсон байна [5].

Эртний нүүдэлчид, тэр тусмаа монголчуудын зэр, зэвсгийн талаар судалгаа хийсэн, археологич доктор Н. Эрдэнэ-Очир “... Эвэр нум нүүдэлчдийн ертөнцөд хүннү болон түүнээс өмнөх хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёлт монгол төрхийн нүүдэлчдийн дунд үүсэн тархсан бөгөөд хожмын нүүдэлчдийн олон төрт улсуудаар улбаалан XIII зууны монголчуудын байлдан дагууллын үед Евразийн хээр талын бүс нутагт тархан “Монгол нум” хэмээх нэрийг олсон байдаг. Монголчуудын эвэр элэгтэй шөрмөсөн артай зүймэл нум нь тухайн үедээ нүүдэлчин ахуйн мал, амьтны гаралтай материалаар бүтсэн технологийн томоохон дэвшил байсан бөгөөд түүний хүчээр Чингис хааны шилдэг жанждын удирдсан арми Евразийн өргөн уудам нутгийн олон улсыг эрхшээсэн хүчирхэг гүрнийг байгуулж чадсан юм...” [8] гэж дүгнэсэн бөгөөд ардын аман зохиолд дүрслэгдсэн “нум” нь “монгол нум” болох нь бидний үзсэн жишээ баримтаас тодорхой байна.

### **Баатарлагийн тууль дахь нумны дүрслэл**

Монголын ардын аман зохиолын баатарлагийн тууль судлаачид эрийн гурван наадам, нум, сумны талаар судалгааны бүтээлдээ дурдсан нь бий. Гэвч тэд зөвхөн тухайн туулийн баатрын дүрийг тодруулах, түүний баатарлаг үйлийг хийхдээ ашигласан зэр зэвсэг талаас нь бичжээ.

Монгол ардын баатарлагийн туульд нум сумны талаар дүрслэгдсэнийг ажиглахад дотор нь: нумны дүрслэл; сумны дүрслэл; нум сум хийх арга технологийн дүрслэл; мэргэн харваачийн ур чадварын тухай дүрслэл; харвааны бай гэж ангилан үзэж болохоор юм. Ингэхдээ монголчуудын нутаг нутгийн туульд өөрсдийн бүс нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан сонин, содон дүрслэл байгааг анхааран судлах хэрэгцээ бидэнд байна. Гэхдээ энэ удаад зөвхөн нумыг хэрхэн дүрслэснийг авч үзэв. Цаашид тус бүрээр нь нарийн ялгамжаатай судалгааны өгүүлэл бичих хэрэгтэй байна.

Монголын ардын баатарлагийн тууль дахь нум хийх арга технологийн талаарх дүрслэл нь бидний сонирхлыг илүүтэй татаж байгаа бөгөөд өнөөгийн нум урлаачдын хийж байгаатай харьцуулан судлах нь цаашид хэрэгтэй юм.

Баатарлагийн туульд монголчуудын эдэлж хэрэглэж байсан нум, сум, харвах арга, харвах бай зэргийг ч тодорхой үзүүлсэн байдаг нь амьдралаас урган гарсан бодит ахуйн тусгал гэдэг нь тодорхой юм. Энэ талаар угсаатны зүйч Х. Нямбуу анх хөндөн судлаж, одоо Б. Нанжид, Н. Эрдэнэ-Очир, Х. Мөнхбаяр нарын судлаачид үргэлжлүүлэн судлаж байна. Монгол ардын туулиудад нумыг олон янзаар дүрслэснийг дараах жишээнээс харж болно.

“Даньхүрэл” туульд:

*Мянган хүчин бүрдсэн*

*Заан цагаан нумын хацарт*

*Хэрээ галуу хоёрыг*

*Живэр живрээр нь харгалдуулаад сийлсэн*

***Тэвхийн аманд нь***

*Хар шар бодон гахайг хадруулаад сийлсэн*

***Баруулд нь бар, луу хоёрын толгойг***

*Барьцалдуулаад сийлсэн*

*Талбиу болтугай гэж*

***Таван зуун хайнагийн эврээр элгэ тавьсан***

*Хатуу болтугай гэж*

***Хатан голын хулсаар гол тавьсан***

*Хүчтэй болтугай гэж*

***Хүдэр хар мангасын шөрмөсөөр зоо тавьсан***

*Догшин хатуу болтугай гэж*

***Хатан хар шуламсын арьсаар***

***Гурван давхар хөвч хийсэн***

*Мянган хүчин төгссөн*

***Хүдэр заан цагаан нумыг***

*Далай хаан аваад хайрлахад....* (Даньхүрэл. 1986. 32-34-р талд)

“Хөх халзан морьтой Хөхөлдэй мэргэн хаан” туульд:

***Тэхийн эвэр элгэвчтэйхэн***

*Тээг модон хөшүүрэгтэйхэн*

*Таван хүний тэнхээтэйхэн*

**Тангад шар хөвчтэй /нум/**  
Хурдан болтугай гэж  
**Хун хэрээний далавчийг наагаад хийсэн**  
Тавиур сайн болог гэж  
**Тасын өдийг наагаад хийсэн**  
Хан гантай хурдан цагаан сумтай (Катуу, 1996, 101)  
“Талын хар бодон” туульд:  
**Зуун тэхийн эврээр**  
**Зузаалж наагаад хийсэн**  
**Жаран тэхийн эврээр**  
**Чандманалж наагаад хийсэн**  
Хүчтэй болтугай гээд  
Хүний зоогийн шар шандсаар  
Давхарлаж наагаад хийсэн  
**Хүрэн улаан чулуун тэвхтэй**  
Харилттай болтугай гээд  
**Хоо барын шандсаар**  
**Хоёр давхарлаж наагаад хийсэн**  
Есөн их хүчтэй  
**Хүдэр шар цоохор нумыг авч** (Талын бодон, 5.15.)  
“Жангар” туульд:  
Ар биеэр нь  
Ар замбуулинг багтааж сийлсэн  
Өвөр биеэр нь  
Орчлон ертөнцийг багтаан сийлсэн  
**Хүдэр шар луун нум**  
Арван гурван сумаа агсаад (Загдсүрэн У., 1978. /1977/. 129)  
“Эрийн сайн хан харангуй” туульд:  
Тэвхэнд нь тэх марал зурсан  
Барцулд нь барс өтөг байгуулсан  
**Мянган хүчит заан цагаан нумтай**  
“... Эрийн сайн  
Хан харанхуй  
**Аргай болсон нумаа авч**  
**Хавцгай болсон сумаа онилтол ...**” (Нарантуяа, 1991.7)  
“Дуутай мөндөр” туульд:  
... Дуутай мөндөр хааны  
Үүрдэг сайн зэр зэв нь гэвэл:  
**Маралын шөрмөсийг**  
**Тэнийлгээд арласан**  
**Тэхийн эврийг**  
**Тэгшилгээд эргэвчилсэн**  
Далан хүн  
Дамжлаад даашгүй  
Тавин гүүний тэнхээтэй  
**Тангад шар нум гэнэ.**  
Хурдан болтугай гэж

*Хун хэрээний далавчийг наагаад хийсэн ...* (Катуу. 1989. 2) гэжээ.

Дээрх туулиудаас харвал өнөөгийн нум хийх арга технологи нь олон зууны турш бараг хэвээр байгааг харж болно. Тэр дундаа хийх арга нь бүр ч хувираагүй уламжлагдсан нь харагдаж байна. Марал буюу бугын шөрмөсөөр арлаж байсныг харж болохоос гадна эврийг Тэхийн эвэр буюу янгирын эврийг өнөө хэр хэрэглэсээр байгааг туулийн дүрслэл бидэнд баталж байна. Мөн сумыг өдлөхдөө хон хэрээний өдөөр хийдэг байсныг мэдэж болохоос гадна, бид өнөөдөр тас шувууны өдийг хэрэглэж байна. Энэ нь аль ч цагт том шувууны өдийг л авч хэрэглэж байсныг харуулж буй хэрэг юм.

Энэ бол эртнээс нүүдэлчин ард түмэн өнөөгийн дэлхий дахинаа “Монгол нум” гэж хүлээн зөвшөөрөгдсөн эвэр элэгтэй, шөрмөсөн арлалтай, хус, хулсаар голыг нь хийсэн нумыг хийж, хэрэглэж байсныг ардын аман зохиолын том төрөл баатарлагийн туульдаа дүрслэн үлдээснийг гэрчилж байна.

Нумны хүч чадлыг орчин үед паундаар юм уу килограммаар тооцож үздэг болжээ. Тэгвэл эрт цагт хэрхэн дүрсэлдэг байсныг “...Тавин гүүний тэнхээтэй Тангад шар нум...” гэсэн дүрслэлээс харж болно. Энэ нь Хэдийгээр тус туулийн он цагийг тогтоох боломжгүй ч гэлээ дүр дүрслэл, байгаа байдлаас нь харвал Их монгол улс байгуулагдсаны дараа зохиогдсон байх боломжтой нь харагдана.

Туульд бас **Тангад шар нум** гэж гарч байна. Энэ нь монголчууд эртнээс харь орны урчуудыг авчирч зэр зэвсгээ хийлгэдэг байсны тусгал гэлтэй байдаг. Тиймдээ ч тангад шар нум гэж дүрсэлсэн байна. Энэ дүрслэл өөр олон туульд гарч байна. “Дуутай мөндөр хаан” туульд нумыг өөр маягаар хийснийг

*“... Аргалын шөрмөсөөр аравч хийсэн  
Тэхийн (ухнын) эврээр элгэвч хийсэн  
Тавин хүний тэнхээтэйхэн  
Тангад шар хөвчийг нь  
Гаргаад ирэхэд  
Арчин түрчин  
Зүүн ташаа дээрээ  
Зүүгээд авав гэнэ ...  
... Хон хэрээний далавчийг  
Наагаад хийсэн...”* (3)  
“Хашин цагаан хаан” туульд  
*“...Тэхийн эврээр элгэвчлээд хийсэн  
Тэгш модыг засаад хийсэн  
Хатуу модыг харуулдаад хийсэн  
Харлаг тэхийн эврийг харшилдуулаад хийсэн  
Тавин хүний тэнхээтэйхэн  
Тангад шар цоохор хөвчийг нь гаргаад  
... Тэнхээ ихтэй болтугай гээд  
Тасын өдийг наагаад хийсэн  
Хурд ихтэй болтугай гээд  
Хун цэнгийн өдийг наагаад хийсэн  
Хаш гантай*

*Хурдан цагаан сумуудыг нь гаргаад...*” (Хашин цагаан хаан, 1978) гэж байгаа нь өмнөх туулийн дүрслэлтэй ижилхэн байна. Энэ бүхнээс дүгнэхэд нүүдэлчдийн олон зуун жилийн туршийн арга туршлагаас нум хийх арга нь бо-

ловсронгуй болж, нэгэнт тогтсон байсныг туулийн дээрх дүрслэлүүд тодорхой харуулж байна.

Энд аргалын шөрмөсөөр арлаж хийжээ. Энэ бол ан гөрөө элбэгтэй газарт суурьшсан монгол туургатны л тухай гарч байгаа бөгөөд ангийн арьс, үс, шөрмөс, эвэр тэргүүтнийг авч ахуй амьдралдаа хэрэглэж байсныг яруу тод харуулсан байна. Тиймдээ ч эртний монголчуудын нум сум гэдэг амьдралын нэгэн салшгүй хэсэг, хийх материал нь хүртэл тэдний ан агнуурын зүйлс байсныг харуулж байна. Аргал, янгир бол монголчуудын эртнээс нааш авлаж, идэш хоолондоо хэрэглэхээс гадна, түүхий эдээр нь ойр зуурынхаа ахуйн хэрэглээг хангаж байсныг харуулсан дүрслэл туульд их байна. Одоо ч гэсэн нумыг янгирын эврээр голлон хийж, заримдаа үхрийн эврээр хийсээр байна.

Доктор Б. Нанжид энэ тухай "... Харин наалт болоод зүйлт, нумын элэг, гичир, зоо, тэвх, хөвч зэрэг бүтээцийн талаар баатарлаг туульд тодорхой дүрслэгдэх бөгөөд өнөөх "хүдэр заан цагаан нум", "эндэрмээ нум", "Ендэрваагийн шар нум"-ыг туулиас элэгтэй нум бол "таван зуун хайнагийн эврээр элэг тавьсан" нааж зүүж хийсэн, "усан хайнагийн эвэр элэгтэй", "жаран тэхийн эврийг жигдрүүлж наагаад хийсэн", загасны хар цөс, загасны шар зусаар наасан, хүдэр хүрэн чулуу, хүрэл хар чулуугаар тэвх тавьсан гэх мэтчилэн дүрслэгдсэн байна. ..." [3] гэж илтгэлдээ дурдаж, энэ талаар илүүтэй сонирхон судлаж байна.

Ардын аман билэгт нумны талаарх дүрслэл арвин баялаг бөгөөд, нутаг нутгийн аман зохиолд өөрсдийн өвөрмөц онцлогийг харуулсан дүр дүрслэл түгээмэл байдаг байна. Үүнээс бид ардын үлгэр туульд гарч байгаа дүр дүрслэл нь бодит амьдралын тусгал байсныг мэдэж болох бөгөөд энэ талаар доктор, профессор А.Очир, судлаач Б.Нанжид нар "Монгол туулийн үүсэл, соёлын давхарга" /2022/ бүтээлдээ эртний буган чулуун хөшөөний дурсгалаас авахуулаад эртний эд өлгийн зүйлийг туулийн дүр дүрслэлтэй харьцуулан шинжилж, бодит амьдралаас сэдэвлэсэн болон уран сайхны харьцааг тодруулан судласан нь сонирхолтой ажил болсон байдаг. Тухайлбал, тус бүтээлд "... Хайнагийн эвэр. Зарим туульд, баатрын нумыг хайнагийн эврээр элэглэж, бас хайнагийн эврээр арлан хийсэн тухай өгүүлж байна.

*... Эзэн улаан бодонгийн нумыг*

*Элдэг болтугай гэж*

*Элэн талд нь*

***Усан хайнагийн эврээр***

*Элгэлж наагаад хийсэн ... (Эзэн улаан бодон 1960: 103)*

*... Талбиу болтугай гэж*

*Таван зуун усан*

***Хайнагийн эврээр эклэ тавьсан...*** (Бум-Эрдэнэ 2006: 82)

*... Усан хайнагийн эврээр*

*Элгэлж наагаад хийсэн*

*Ендэрмээн шар цоохор нум* (Наран хаан хүү 2006: 381)

Хайнаг нь сарлаг, монгол үхрийн эрлийз мал юм. Гол төлөв ойрад (Алтай)-ын туульд хайнагийн эврээр нум элэглэсэн тухай гарч байна. Одоо мэдэгдэж байгаагаар, монгол орон болон түүний зах залгаа нутгаас археологийн малтлагаар олдсон хүрэл зэвсэг үйлдвэрлэлийн хийгээд түүнээс хойших үеийн нумуудыг бугын эврээр элгэлсэн байдаг. Ер нь сарлаг төвдийн Химлайн уулаас гаралтай бөгөөд XIII зууны орчинд монгол нутагт нэвтрэн ирсэн гэж ихэнх судлаачид үздэг.

Түүнээс өмнөх үеийн булш болоод бусад дурсгалаас одоо хэр сарлаг (хайнаг)-ийн яс олноогүй аж. Иймд наад зах нь XIII зуунаас хойш л хайнаг (сарлаг)-ийн эврээр нум элэглэж бас арлаж байсан болов уу...” [6] гэж бичсэн байна. Энэ нь туулийн гарал үүслийг тодруулахад тустай бөгөөд шинжэх ухаан хоорондын уялдаан дунд ардын аман билгийг судлан шинжлэхэд чухал түлхэц болсон ажил болсон байдаг.

Монголчуудын бичиг соёлын тайлбар толиудын нэг “Гучин зургаатын тайлбар толь” /2005/-д нум сумны зүйл, харвах намнах зүйлийн талаар тусгайлан дэвтэр болгон тайлбарласан байдаг бөгөөд түүнд монголчуудын нумны зүйлийг тусгайлан нэрлэсэн зүйлийг товчоолон оруулж бичсэн байдаг. Монгол цэргийн зэвсгийн талаарх нарийн судалгааг хийсэн профессор Ж. Базарсүрэн нум сумны талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг бөгөөд судлаачдын тогтоосноор 20 орчим төрөл [7] байдаг аж. Профессор Ж. Базарсүрэн тэмдэглэхдээ “...Монгол цэрэг дайн байлдаанд явахдаа хүн бүр наад зах нь хатуу, зөөлөн хоёр, гурван төрлийн нумтай, дүүрэн зэв, сумтай гурван саадагтай /60–90 ширхэг сумтай/ явдаг байжээ. Дундад эртний үеийн монгол цэргийн хамгийн зөөлөн нум нь 30 орчим килограммын таталттай байсан бөгөөд тийм нумаар хорь, гучин алхамын дотор хир баргийн хуягийг нэвт харвадаг байж. Харин хамгийн хүчит, хатуу нум нь “Төмөр буюу болд ширхэгт нум” бөгөөд тийм нумын татал 70–80 килограммаас багагүй байв.

Монгол цэргийн нум сумны ашигтай тусгал 200–300 метр, хаймсах алсын тусгал 600–700 метр, түүнээс ч их байсан нь монгол цэрэг тулалдааныг 200–300 метрийн алсаас эхлэх боломж олгож байв. Энэ нь охор зэвсэгт суурин улсын ихэнх цэргийн хувьд амжилттай тулалдах боломжгүй холын зай байлаа...” [7] гэж дурджээ. Энэ бүхнээс үзэхэд ардын аман билэгт туссан нум сумны аливаа дүрслэл нь бодит амьдралаас урган гарсан, уран сайхны сэтгэлгээнд ууссан дүрслэл болох нь харагдаж байна. Бодит амьдралын тусгал нь ардын аман зохиол байдгийг санаж, цаашид аман билгийн яндашгүй өвийг эртний судлалтай хослуулан шинжлэх нь ихээхэн утга учиртай болохыг энд дурдая.

#### **Дүгнэлт**

Монголчууд нь эртний нүүдэлчин аймгийн нэгэн бөгөөд нум анх хийж, улмаар хөгжүүлэн, өөрсдийн онцлогтой “монгол нум” хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн зэвсгийг хэрэглэж ирсэн нь түүхийн олон эх сурвалжаар батлагдаж байна.

Энэхүү монгол нум нь тэдний ардын аман зохиолд түгээмэл дурдагдан үлдсэн нь аман уламжлалаар “монгол нум” байсныг гэрчилж байгаа хэрэг бөгөөд баатарлагийн тууль дахь нумны дүрслэл нь дээрх санааг батлаж байгаа аман баримт, мэдээ болж байна.

Монголчуудын угсаа бүлгийн ялгаатай байдал нь баатарлагийн тууль дахь нумны дүрслэлээс тодорхой харагдах бөгөөд нутаг орны ялгаатай байдал нь нумыг хийх арга, технологид нөлөөлж байсныг ч соёлын талаас нь анзаарч болохоор байгаа бөгөөд цаашид судлууштай сэдэв мөн юм.

Гэвч уран сайхны, хийсвэр сэтгэлгээний зүйлийг нь салгаж, амьдралд байсан бодит үнэнийг олж тодруулвал нум сум хийх арга технологио ардын аман зохиолдоо шингээн хойч үедээ өвлүүлсэн болохыг мэдэж болохоор байна. Иймээс тууль, ардын үлгэрт байгаа нум сумыг хийх арга ажиллагаа, түүний орц, найрлагыг анхааран үзэж, цаашид тоддуулан авч үзэх нь уламжлалт өв соёлоо зөв зүйтэй сэргээн босгоход ихээхэн түлхэц болно гэж үзэж байна.

### Ном зүй

1. Дамдинсүрэн А. Монголын зэвсгийн товч түүх. Улаанбаатар, 1990. 44-р талд.
2. Катуу Б. Монгол туулийн дүрийн тогтолцоо, Хянан тохиолдуулсан: Акад. Х. Сампилдэндэв. Улаанбаатар, 2004. 107-р талд.
3. Нанжид Б. Монгол баатарлаг тууль ба нум [Хэвлэгдээгүй өгүүлэл].
4. Нямбуу Х. Туульсийн баатруудын хувцас // Шинжлэх ухаан амьдрал, сэтгүүл, Улаанбаатар, 1987. № 6. 17-р талд.
5. Одсүрэн Д. Шинэ чулуун зэвсгийн үеийн харвуулын сумны чулуун зэв // Нүүдэлчдийн өв соёл ба спорт / Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан бүтээв / Хамтын бүтээл. Улаанбаатар, 2024. 13, 19-р талд.
6. Очир А., Нанжид Б. Монгол туулийн үүсэл, соёлын давхарга / редактор Б. Түвшинтөгс. Улаанбаатар, 2022. 86-р талд.
7. Үлэмжийн их Чингис хаан (Эрдэм шинжилгээний бага хурлын материал) Хянан нягталсан, академич Ж. Болдбаатар. Улаанбаатар, 2009.
8. Эрдэнэ-Очир Н. «Монгол нум»-ын үүсэл хөгжил // Нүүдэлчдийн өв соёл ба спорт / Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан бүтээв / Хамтын бүтээл. Улаанбаатар, 2024. 143-р талд, 156-р талд.

### Эх сурвалж буюу жишиг татсан туулиуд

- «Даньхүрэл» тууль, Эмхэтгэсэн Б. Катуу. Улаанбаатар, 1986.  
«Хөх халзан морьтой Хөхөлдэй мэргэн хаан» тууль, Эмхэтгэсэн Б. Катуу. Улаанбаатар, 1996.  
«Эрийн сайн Хан-Харанхуй» Халх тууль (МАЗ-ын дээж бичиг). Улаанбаатар, 1978.  
«Дуутай мөндөр» (Монгол ардын туульс) / Б. Катуу, Р. Нарантуяа; ред. Х. Сампилдэндэв, БНМАУ. Улаанбаатар, 1989. Увс аймгийн Г.Хайнзан туульчийн хайлсан тууль.  
«Хашин цагаан хаан» тууль, (МАЗ-ын дээж бичиг). Улаанбаатар, 1978.  
«Халх ардын тууль», Эмхэтгэсэн Р. Нарантуяа. Улаанбаатар, 1991.  
«Жангар» / редактор Ц. Дамдинсүрэн. Улаанбаатар, 2008. 95 талд.

Нийтлэлийг редакторууд 2025 оны 11-р сарын 20-нд хүлээн авсан; 2025 оны 11-р сарын 27-нд хянасны дараа батлагдсан; 2025 оны 12-р сарын 1-нд хэвлүүлэхээр хүлээн авсан.

## The Depiction of the Bow in Heroic Epics

*Myagmasuren Odmandakh*

Ph.D., A/Prof.

Mongolian National University of Education

Sukhe-Batora St., 14191 Ulaanbaatar, Mongolia

odmandakh@msue.edu.mn

*Abstract.* Mongolian scholars have conducted extensive research on the bow immortalized in world history under the name *Mongol bow* examining archaeological artifacts, rock paintings, and ancient traces to draw well-grounded conclusions. Among the genres of folklore relevant to the study of the *Mongol bow*, the heroic epic holds particular significance. A comparison between the bow depicted in heroic epics and bows crafted by modern bowmakers shows no fundamental differences. Moreover, the similarities between these descriptions and bows recovered from archaeological sites indicate that bow-making techniques were perfected centuries ago and have been faithfully preserved to this day. In

the article, the author has attempted to compare scholarly findings on bows recovered from ancient artifacts with depictions of the bow in heroic epics to determine their degree of correspondence.

*Keywords:* heroic epic, bow, oral tradition, epic.

*For citation*

Myagmasuren Odmandakh. The Depiction of the Bow in Heroic Epics. *Buryat Language and Literature in School*. 2025; 4: 34–43 (In Mong.)

*The article was submitted 20.11.2025; approved after reviewing 27.11.2025; accepted for publication 01.12.2025.*